

Нийслэлийн Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га ойн төглийг хашаалах ажил гүйцэтгэлийн удирдамж

Байгууллага:	Хүүхдийг Ивээх Сан ТББ
Төслийн нэр:	Ойн төгөл бүтээгч хүүхдүүд
Байршил, хэмжээ:	Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га
Ажлын зорилго:	Хашаа нийлүүлэх, хашааг барих ажил гүйцэтгэл
Ажил гүйцэтгэх хугацаа:	2025.04.15 –2025.04.30 (нийт 15 хоног)

Үндэслэл

Японы Хүүхдийг Ивээх Сан /ХИС/ нь хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, эрүүл мэнд, хүүхдийн ядуурлыг бууруулах болон хүмүүнлэгийн чиглэлээр төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлдэг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм.

ХИС нь хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох алсын хараатай, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах эрхэм зорилготой.

ХИС нь 2024 оны 8 дугаар сараас эхлэн Нийслэлийн Налайх дүүрэгт иргэд, хүүхэд багачуудын оролцоотойгоор ойн төгөл байгуулж ногоон орчныг нэмэгдүүлэх, мөн тэдний уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

“Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн үйл ажиллагааны хүрээнд 2025 оны эхний улиралд хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан “Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт сургалтыг Налайх Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон төслөөс бэлтгэгдсэн сургагч багш нартай хамтран зохион байгуулж эхлээд байна. Тус ажлын хүрээнд “Жимс жимсгэнэ, мод сөөгийн үрсэлгээ, үржүүлэг хийх арга”, “Байгалаа бүтээе” сургалтыг Дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгууллаа. Үүнд нийт 300 гаруй иргэд хамрагдаж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл авснаас гадна мод, жимс жимсгэнэ тариалж ногоон орчин бүрдүүлэх, амьжиргаагаа сайжруулах боломжийн талаар суралцав. Цаашид давхардсан тоогоор Налайх Дүүргийн 1,500 гаруй хүүхэд, залуучууд, иргэдийг хамруулахаар төлөвлөөд байна. Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.savethechildren.mn -аас авна уу.

Гэрээт ажлын зорилго

Нийслэлийн Налайх дүүрэгт хэрэгжиж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд төсөл”-ийн 5га талбайг зохих стандарт шаардлагын дагуу хашаалах, хашааны гүйцэтгэлийг зурагт заасны дагуу чанартай, аюулгүй байдлыг ханган хийж гүйцэтгэхэд тус гэрээт ажлын зорилго оршино.

Ажил гүйцэтгэх хугацаа

2025 оны 4-р сарын 15 өдрөөс 2025 оны 4-р сарын 30 өдөр (нийт 15 хоног)

Ажил гүйцэтгэгчид тавигдах үндсэн шаардлага

- Нийлүүлэлт угсралт хашааны гүйцэтгэл хийх бүрэн чадвартай хүн хүч техник

- хэрэгсэл, материалын нөөцтэй байх,
- Өмнө нь хашааны материал нийлүүлж мөн хашаа барих, суурилуулах ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх,
- Чанар, стандарт, аюулгүй байдлыг чанад мөрддөг байх,



Талбайн төлөвлөлт

Үндсэн агро-ойжуулалтын цэцэрлэгийн /40,000м²/

Мод үржүүлэг, бусад талбай /10,000м²/

а.Хашаа нь хамгийн багадаа дараах шаардлагыг хангасан байх.


Төмөр шон	50мм-60мм*50мм-60мм-н квадрат 25-28мм зузаан	Өндөр 1,800мм	Төмөр, Резинэн будагтай
Баганын чигжээс		400мм	Бетон
Хашааны тор	100*100мм	1,400мм	Ган, зэвэрдэггүй сайн чанарын сүлжмэл тор
Хашааны тор /мэрэгчээс хамгаалсан/	50*50мм	400мм	Ган, зэвэрдэггүй сайн чанарын сүлжмэл тор
Хашаа	Шон хоорондын зай 3500мм	100*100мм тор болон 50*50мм хамгаалалтын тор зөрүүлэх хэмжээ 100мм,	
Каттинг	8 диаметртэй сайн чанарын арматур торны дээр доор зангидна.		

б.Хаалга хамгийн багадаа дараах шаардлагыг хангасан байна.

Төмөр шон	100*100мм-н квадрат 25-28мм зузаан	Өндөр 2,000мм	Резинэн будагтай
-----------	---------------------------------------	---------------	------------------

Баганын чигжээс	Бетон	400мм	
Хаалга	Шон хоорондын зай 5,800мм Торны өндөр 1,800мм	50-70мм Ган, зэвэрдэггүй сайн чанарын хаалганы /бэлэн/ тор, роликтой	
Хүрээ	50*50мм квадрат		

Байршлын газрын зураг, хэмжээ

Газрын байршлын зураг	Цэг	Зай
	1-2	174.3
	2-3	53.60
	3-4	243.04
	4-5	259.93
	5-6	130.24
	6-1	58.66

Ирүүлэх материалууд:

- Энэхүү ажлыг гүйцэтгэхээр сонирхлоо илэрхийлсэн албан бичиг
- АА нэгжийн гэрчилгээ, Байгууллагын танилцуулга
- Үнийн санал. Нийлүүлэлт, ажлын хөлс, техник хэрэгсэл, тээвэр, татвар хураамж бүгд багтсан үнийн саналыг жишиг үнийн саналын маягтын дагуу эсвэл нарийвчилсан төсөв ирүүлнэ.
- Гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө
- Сүүлийн 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ижил төстэй гэрээт ажлуудын /хашааны/ жагсаалт
- 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх материалуудыг битүүмжлэн дараах хаягаар хүргүүлнэ үү. Японы Хүүхдийг Ивээх Сан, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төвийн 4-р давхар. Материал хүлээн авах эцсийн хугацаа: **2025 оны 4 сарын 3-ны өдрийн 17:00 цаг.**

Жишиг үнийн саналын маягт:

Огноо:

Японы Хүүхдийг Ивээх Санд

1. Нийслэлийн Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га ойн төглийг хашаалах ажил гүйцэтгэлийн сонгон шалгаруулалтад дор дурдсан жагсаалтын дагуу _____ тоогоор _____ үсгээр үнийн саналын баримт бичгийн дагуу _____ хоногт хийж гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Энэхүү үнийн дүнд холбогдох татвар, даатгал, ажлын хөлс, техник хэрэгсэл, материалын задал орсон.
3. Ажлын удирдамж болон ажлын зурагт тавигдсан шаардлагыг хангаж байгааг гэрчилж байна.

	Материалын нэр	Үзүүлэлт	Хангаж байгаа болон түүнээс дээш (тийм/үгүй)
1	Төмөр шон	Шон Өндөр 1800мм 50мм-60мм*50мм-60мм төмөр квадрат Зузаан 25-28мм резин будагтай Чигжээс 40мм бетон	
2	Хашааны тор	Нийт өндөр 1,800мм Өндөр 1,400мм 100мм*100мм харьцах зэвэрдэггүй ган сүлжмэл тор Өндөр 400мм 50мм*50мм харьцах зэвэрдэггүй ган сүлжмэл тор хамгаалалтын тор. 2 төрлийн Тор зөрүүлэх хэмжээ 100мм	
3	Арматур	Торны дээгүүр болон доогуур 8мм диаметртэй каттинг арматур зангидна. Шон хоорондын зай 3,500мм	
4	Хаалга	Хаалга 6,000мм*1,800мм Шон Өндөр 2,000мм Квадрат 100мм*100мм төмөр Зузаан 25-28мм төмөр, резин будагтай Чигжээс 40мм бетон Хүрээ Өндөр 1,800мм Урт 6,000мм, 50мм*50мм квадрат төмөр, резин будагтай Тор	

		<p>Өндөр 1,800мм 50мм*50мм сайн чанарын зэвэрдэггүй бэлэн, ган тор. Роллик, бетондсон замтай</p>	
5	Явган хүний хаалга	<p>Хаалга 900мм*1800мм Шон Өндөр 2,000мм Квадрат 100мм*100мм 25-28мм зузаан төмөр резин будагтай Хүрээ Өндөр 1,800мм Урт 900мм, 50мм*50мм квадрат Тор Өндөр 1,800мм 50мм*50мм сайн чанарын бэлэн зэвэрдэггүй, ган тор.</p>	
6	Ажлын гүйцэтгэлтэй холбоотой бусад материал		